

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД МОНГОЛ УЛС-АНУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

*М.Хурметхан**

I

Монгол Улсын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд нэгдэн нийлэх талаар тодорхой арга хэмжээнүүд хэрэгжүүлж байгаагийн дотор АНУ-тай худалдаа, эдийн засгийн хувьд бүх талаар хамтран ажиллах нь чухал байр эзлэх болов. Эдийн засгийн хүчирхэг орнуудаас, түүний дотор АНУ-аас Монгол Улстай худалдаагаа өргөжүүлэн, хөрөнгө оруулах сонирхол сүүлийн жилүүдэд өсч байгаа бөгөөд уул уурхай, хөдөө аж ахуй гэх мэт салбарт түлхүү орох болов. Энэ нь АНУ-ын капитал, технологи, ноу хау, менежментийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжилд түлхэц өгч, улмаар эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй билээ. АНУ-ын хөрөнгө оруулалт нь бодит эдийн засагт сайнаар нөлөөлж байгаа бөгөөд улмаар АНУ-ын хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах шаардлага тулгарч байгаа юм. АНУ нь манай улсын эдийн засагт гүйцэтгэж байгаа үүргийн хувьд томоохон хүчин бас ивээн тэтгэгч билээ. Ийнхүү, Монголын эдийн засаг нь Америкийн эдийн засгаас нилээд хүчтэй хамааралтай болсон боловч санасан хэмжээ, түвшинд хараахан хүрээгүй байгааг судлан харуулав.

II

2007-2009 онд Монгол Улс, АНУ-ын хоёр талын харилцааны хүрээнд улс төрийн яриа, хэлэлцээг бүхий л түвшинд тогтмолжуулан идэвхтэй явуулж, өндөр дээд хэмжээнд айлчлал хэрэгжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудалд түлхүү анхааран соёл, хүмүүнлэгийн харилцааг идэвхжүүлэхийг урьдын адил чухалчлан ажиллаж ирсэнийг өнгөрсөн жилүүдийн түүх гэрчилж байна.

Монгол Улс - АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа /2007 он/

Сүүлийн гурван жилийн турш Монгол-Америкийн харилцаа, хамтын ажиллагааг иж бүрэн түншлэлийн үзэл санааны дагуу хөгжүүлэх зорилт тавин ажилласны үр дүнд 2007-2009 онд эдийн засгийн хамтын ажиллагааны байдалд нааштай өөрчлөлт гарах төлөв бий болов. 2007 онд Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ой тохиосон бөгөөд энэ нь хоёр талын харилцааг өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг жилийн турш хэрэгжүүлэхэд тус дөхөм болсон юм.

Хоёр талын харилцааны хамгийн чухал үйл явдал болох Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 10 дугаар сард АНУ-д хийсэн албан

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

ёсны айлчлал нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд чухал түлхэц өгөв. Айлчлалын гол үр дүн нь Мянганы Сорилтын Сангаас 285 сая ам.долларын буцалтгүй тусламж авах тухай Ерөнхий хэлэлцээр байгуулсанд оршино. Айлчлалын үеэр хоёр орны харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэхэд ач холбогдол бүхий хэд хэдэн гэрээ хэлэлцээр байгуулснаас гадна иж бүрэн түншлэлийн зарчмуудыг тодорхойлсон “Ойр хамтын ажиллагааны зарчмуудын тухай Тунхаглал”-д Гадаад хэргийн сайд нарын түвшинд гарын үсэг зурсан билээ. АНУ-ын зүгээс ч гэсэн Монгол Улсын төрийн тэргүүний айлчлалд урьд урьдаас илүү ач холбогдол өгч, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг иж бүрэн түншлэлийн зарчмуудын дагуу бүхий л салбарт цаашид өргөжүүлэн хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлээ нотолсон билээ. Айлчлал дэлхий нийтийн анхаарлыг Монгол Улсад хандуулах, сурталчлахад ч багагүй ач холбогдолтой болсон билээ.

2007 онд хоёр орны хууль тогтоох байгууллагын харилцаа, хамтын ажиллагаа ахицтай явагдав. Парламент хоорондын харилцан айлчлал болсноос гадна хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойг тохиолдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийг уриалсан тогтоолыг АНУ-ын Сенат батлав.

Гадаад хэргийн яам, АНУ-ын Төрийн департамент хоорондын ээлжит дөрөв дэх зөвлөлдөх уулзалтыг 2007 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан юм. Уулзалт харилцааны тэгш ойн жил болж байгаатай холбогдуулан түүнд холбогдох яам, газруудыг оролцуулан өргөн хүрээнд хийж, салбарын хамтын ажиллагааны байдал, зорилтын талаар мэдээлж ярилцсан нь хамтын ажиллагааг агуулга, хэлбэрийн хувьд баяжуулан өргөжүүлэх, иж бүрэн түншлэлийн харилцааг батжуулах, харилцааны тулгамдсан асуудлуудыг урагшлуулахад ач холбогдолтой болсон билээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш 2007 оны 3 дугаар сард, дэд Ерөнхийлөгч Р.Чейни 2007 оны 9 дүгээр сард тус тус Монгол Улсын Ерөнхийлөгчтэй анх удаа утсаар шууд ярьсан нь хоёр орны харилцааны хүрээнд гарсан онцлог явдал болов. Хэдийгээр АНУ-ын гол сонирхол Ирак дахь Монгол Улсын зэвсэгт хүчний оролцоог үргэлжлүүлэхэд оршиж байсан боловч манай тал тэрхүү завшааныг ашиглан Мянганы Сорилтын Сантай гэрээ байгуулж тусламж авах явдлыг түргэвчлэх, монголын залуусыг АНУ-ын Засгийн газрын тэтгэлгээр сургах явдлыг нэмэгдүүлэх зэрэг харилцааны хувьд тулгамдсан асуудлуудыг сөргүүлэн тавьсан нь ач холбогдолтой болж, зарим нь 2007 онд Ерөнхийлөгчийн АНУ-д хийсэн айлчлалын дүнд тусгалаа олсон билээ.

МСС-тай Ерөнхий хэлэлцээр байгуулснаар хоёр талын эдийн засгийн харилцааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх чухал суваг нээгдэв. Монгол-Америкийн худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн

бэхжүүлэхэд чиглэсэн “Бизнес форум”-ын уулзалтыг 2007 онд хоёр дахь удаагаа зохион байгуулсан нь эдийн засгийн харилцааг идэвхжүүлэхэд түлхэц өглөө.

Салбар хоорондын хамтын ажиллагаанд тодорхой ахиц гарав. Тухайлбал, “Юнайтед Уорлд Коллеж” сургуулийн салбарыг Монголд нээх, монгол оюутныг тус сургуульд илгээж сургах, “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутгийн сургуулийн хүүхдүүдийг зөөврийн компьютерээр хангах тохиролцоонд хүрэв.

Батлан хамгаалах салбар дахь хамтын ажиллагаа урьдын адил эрчимтэй явагдаж ирэв. “Хааны эрэлд 2007” хээрийн сургууль Монгол Улс энхийг сахиулахад идэвхтэй оролцох боломжтойг нотлон харуулах, Монгол Улсын олон улсын нэр хүндийг өргөхөд ач холбогдолтой бүс нутгийн арга хэмжээ болов. АНУ-ын нэр нөлөө бүхий төрийн бус байгууллага болох “Байгаль хамгаалал” байгууллага Монголын бэлчээрийг хамгаалах талаар төсөл хэрэгжүүлэх болсноор байгаль хамгаалах, талхигдсан байгаль орчныг нөхөн сэргээх асуудал хоёр талын хамтын ажиллагааны нэг чиглэл болох нөхцөл бүрдэв.

Азийн нийгэмлэгээс жил бүр Азийн аль нэг оронд зохион байгуулдаг дэлхийд нэр хүнд бүхий Уильямсбургийн бага хурлыг 2007 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо анх удаа зохион байгуулсан нь харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд гарсан бас нэгэн онцлог үйл явдал болов. АНУ-ын Төрийн Департаментын Туслах нарийн бичгийн дарга Кристофер Хилл бага хуралд оролцонгоо ажлын айлчлал хийсэн билээ.

Орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ч ахиц гарав. Эрдэнэт, Файрбанкс хотуудын хооронд ах дүү хотын харилцаа тогтов. Талууд харилцаа, хамтын ажиллагааг боловсрол, уул уурхай, аялал жуулчлалын чиглэлээр түлхүү хөгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахаар тохиролцон ажилласан он байлаа.

Монгол Улс АНУ-ын талын хүсэлтийг харгалзан ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн дагуу Иракийн дайны дараах гамшгийг арилгах, сэргээн босгох, энхийг сахиулах хүмүүнлэгийн олон улсын ажиллагаанд манай Зэвсэгт хүчний 7 дугаар ээлжийн багийн хугацааг сунган оролцуулж, дараа нь 8 дугаар ээлжийн багийг илгээн оролцуулсан билээ. Энэ нь батлан хамгаалах төдийгүй нийт харилцааны байдалд нөлөөлсөн чухал хүчин зүйл болсон билээ.

Монгол Улс - АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа /2008 он/
2008 онд Гадаад хэргийн яам, АНУ-ын Төрийн департамент хоорондын ээлжит дөрөв дэх зөвлөлдөх уулзалтыг Монгол-АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн Хамтарсан зөвлөлийн дөрөв дүгээр хуралтай хамтруулан Вашингтон хотноо зохион байгуулсны зэрэгцээ хоёр талын консулын харилцааны асуудлуудыг анх

удаа хэлэлцсэн нь онцлог үйл явдал болов. Төрийн Департамент уулзалтад урьд урьдаас илүү ач холбогдол өгч, хэлэлцсэн асуудал бүрээр холбогдох яам, газруудынхаа албаны хүмүүсийг өргөнөөр оролцуулсан нь ажил хэрэгч уур амьсгалыг бий болгож, санал солилцоог илүү үр өгөөжтэй болгосон байна. Зөвлөлдөх уулзалтын үеэр АНУ нь Монгол Улстай гурав дахь хөршийн хувьд харилцаж буй гэдгийг Төрийн департаментын Туслах нарийн бичгийн дарга К.Хилл тэмдэглэн хэлжээ.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 63 дугаар чуулганы хуралдаанд оролцоод АНУ-ын Вашингтон хотноо ажлын айлчлал хийж Дэд ерөнхийлөгч Р.Чэйни, Конгрессын Төлөөлөгчдийн танхим дахь Америк-Монголын найрамдлын бүлгийн ахлагч Жоу Питтс, Жоу Уилсон, Бүгд найрамдах болон Ардчилсан намын хүрээлэнгүүдийн удирдлага, албаны хүмүүстэй уулзаж ярилцжээ. Ерөнхий сайдын ажлын айлчлалын үеэр Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, АНУ-ын Дотоод хэргийн яам хооронд байгаль орчны салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2008 оны 12 дугаар сард БНХАУ-ын Хонгконг хотноо болсон Клинтонь дэлхийн санаачилгын Азийн уулзалтад оролцож Б.Клинтонтой уулзаж, хатагтай Клинтон АНУ-ын ТНБД-аар ажиллах болж буйд нь баяр хүргэж, түүнийг Монголд дахин айлчлан ирнэ гэж найдаж байгаагаа илэрхийлсэн байна. Уулзалт Б.Обамагийн Засгийн газрын ТНБД-д хандсан утгаараа ач холбогдолтой үйл явдал болсон байна.

Мөн онд бусад түвшин, чиглэлээр ч зарим уулзалт хэрэгжсэн байна. Тухайлбал, 2008 оны 2 дугаар сард болсон БНСУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын үеэр Гадаад хэргийн сайд С.Оюун АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга К.Райстай уулзан, Төрийн Департаментын Туслах нарийн бичгийн даргын орлогч Т.Кристенсен 5 дугаар сард, Хятад, Монголын асуудлыг эрхлэх газрын захирлаар томилогдсон Д.Шиэр 5 дугаар сард, Төрийн департаментын Гадаад албаны институтын Ерөнхий захирал Х.Томас 3 дугаар сард, ҮАБЗ-ийн Стратегийн төлөвлөлтийн Ахлах захирал П.Леттоу, мөн газрын ажилтан Д.Твайнин нар 6 дугаар сард, АНУ-ын “Nature conservancy” байгууллагын АНД-ийн бүсийн дэд дарга И.Даттон 8 дугаар сард, АНУ-ын “Дэлхийн өсөлт” байгууллагын тэргүүн А.Оксли, төлөөлөгч Н.Содерберг нар 8, 11 дүгээр сард тус тус ажлын айлчлал хийсэн нь хоёр талын харилцааг олон салбар чиглэлд хөгжүүлэхэд түлхэц болжээ.

2008-2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 онд АНУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэд хэдэн арга хэмжээ хэрэгжүүлээ. Тухайлбал, МСС-тай Ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монголын талын байгууллага байгуулагдаж, төслийн анхны санхүүжилт орж ирж, МСС-гийн 285 сая ам.долларын буцалтгүй тусламж хэрэгжих шатандаа орлоо. “Хүүхэд бүрт

компьютер” хөтөлбөрийн тэргүүн Н.Негропonte 7 дугаар сард манайд ажлын айлчлал хийсэн зэргээс гадна АНУ-ын Калифорни мужид дэгдсэн ойн түймэрт өртөгсдөд олгох хүмүүнлэгийн 50 мянган ам.долларын тусламжийг манай ард түмэн үзүүлэв. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр ярилцсаны дагуу Аляскийн байнгын сангийн корпорацийн үйл ажиллагаатай танилцах ажлын хэсгийг Аляскад илгээж туршлага судлуулав.

Америкийн засаг захиргаа Иракийг сэргээн босгох үйл ажиллагаанд оруулсан Монголын хувь нэмрийг өндөр үнэлэв. Тухайлбал АНУ-ын дэд Ерөнхийлөгч Р.Чейни Ерөнхий сайд С.Баяртай 9 дүгээр сард Вашингтонд уулзахдаа, АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш 11 дүгээр сард Ерөнхийлөгч Н.Энхбаярт захидал ирүүлэхдээ ийнхүү талархал илэрхийлжээ.

2008 онд Монгол, Америкийн “Бизнес Форум”-ын 3 дахь уулзалт Вашингтон хотноо болоход АНУ-ын Худалдааны сайд нээж үг хэлэв. Форум урьд урьдаас өргөн хүрээнд болж, худалдаа, эдийн засгийн харилцаанд түлхүү анхаарч, түүний мөрөөр АНУ-ын Худалдааны Яамны олон улсын худалдааны асуудал эрхэлсэн дэд сайдын орлогч тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад айлчлав.

АНУ-ын Худалдааны яамны Олон улсын худалдааны асуудал эрхэлсэн орлогч сайд Мишел О’Нейл тэргүүтэй төлөөлөгчид 2008 оны 9 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Монгол Улсад айлчилжээ. Энэхүү айлчлал нь АНУ-аас Монгол Улсад хийж буй анхны худалдааны айлчлал байснаараа ихээхэн ач холбогдолтой юм. “Монгол Улс чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж буй нь АНУ-ын боловсрол, уул уурхай, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм бэлдмэл, барилга, өндөр технологи болон машин техникийн салбарын хөрөнгө оруулагчид, экспортлогчдод шинэ боломжийг олгож тэдний сонирхлыг татаж буй юм” хэмээн АНУ-ын Худалдааны яамны Олон улсын худалдааны асуудал эрхэлсэн орлогч сайд Мишел О’Нейл энэ үеэр мэдэгджээ.

Энэхүү айлчлал нь бизнесийн төлөөлөгчдөд Монгол Улсын зах зээл, бизнес, шинэ бизнес эрхлэх боломж, хэтийн төлвийн талаар мэдээлэл авч холбогдох хүмүүстэй харилцахад дөхөм үзүүлсэн байна. Айлчлалын хүрээнд бизнесийнхэн Монголын бизнесийнхэн, засгийн газрын албаны хүмүүс, худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөгчидтэй уулзжээ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Монголд бизнес эрхлэх сонирхолтой төрөл бүрийн салбарын бизнесийнхэн орсон бөгөөд айлчлалын үеэр төлөөлөгчид 9 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд зохиогдсон Хойд Америк Монголын бизнесийн зөвлөлийн Хөрөнгө оруулагчдын 11 дүгээр ээлжит бага хурал, Ерөнхий сайдын дугуй ширээний уулзалтад мөн оролцсон байна.

АНУ-ын хувийн хэвшлийнхний зүгээс ч манай улсад хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлж байв. Тухайлбал, Пибоди энержи компанийн ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал тэргүүтэй төлөөлөгчид

2008 оны 10 дугаар сард ирж Таван толгойд хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхлоо дахин илэрхийлж байжээ. АНУ-ын хувийн хэвшлийнхний Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол 2008 оны 9 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо болсон Хойд Америк, Монголын бизнесийн зөвлөлийн Хөрөнгө оруулагчдын 11 дүгээр хурлын үеэр ч ажиглагдсан байна.

Вашингтон дахь Монгол Улсын ЭСЯ, АНУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран Монголын соёлын өдрүүдийг АНУ-ын Охайо мужийн Мидлтаун хотноо 2008 оны 11 дүгээр сард зохион байгууллаа. Мөн онд АНУ-ын иргэд Монгол Улсад 90 хоногт визгүй зорчихоор харилцан тохирсон байна. АНУ-ын ЭСЯ-наас зарладаг Фулбрайтын тэтгэлгийн шугамаар 28 оюутан магистрын сургалтад, Хамфригийн тэтгэлгээр 11 оюутан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байв. Голдуу хувийн болон шашны байгууллагын шугамаар 1000 гаруй монгол оюутан (бүрэн бус мэдээгээр) АНУ-д сурч байгаа гэсэн мэдээ гарч байлаа. АНУ-д ЭСЯ-ны 2007 оны 12 дугаар сард хийсэн судалгаагаар 20 мянга орчим монгол иргэд сурч, ажиллаж байв. Тэд голдуу Оакланд, Денвер, Чикаго, Лос Анжелес, Сан Франциско, Сиэтл, Сакраменто, Лас Вегас, Вашингтон, Охайо, Нью-Жерси, Орноак, Юта, Нью-Йорк, Флорида зэрэг хэд хэдэн мужийн 120 орчим хотод оршин сууж байв.

Монгол Улс - АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа /2009 он/
2009 оны 6-р сард Монгол Улсын Гадаад харилцааны сайд С.Батболд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтонтой Төрийн департаментад уулзаж, хэлэлцээ хийсэн байна. Уулзалт хэлэлцээний үеэр Сайд С.Батболд Монгол, Америкийн харилцааны өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, иж бүрэн түншлэлийн харилцааг улс төр, худалдаа, эдийн засаг, боловсрол, хүрээлэн буй орчин, батлан хамгаалах зэрэг бололцоотой бүх салбарт өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд “Ил тод байдлын хэлэлцээр” байгуулахын чухлыг дурдаад, уг хэлэлцээг байгуулах ажил удахгүй эхэлж байгааг тэмдэглэсэн байна. МСС-гийн Төмөр замын төсөлд хуваарилагдсан хөрөнгийг Монголд нэн шаардлагатай байгаа Улаанбаатар хотын агаарын бохирдлыг арилгах, хурдны зам барих болон МСС-гийн шугамаар эдүгээ хэрэгжүүлж байгаа гурван төслийг өргөтгөн санхүүжүүлэхэд шилжүүлэхийг хүсэлт болгож, дэмжлэг үзүүлэхийг ТНБД Х.Клинтоноос хүссэн байна.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Монголд сөргөөр нөлөөлж байгааг хэлж, АНУ-ын зүгээс хямралд нэрвэгдсэн хөгжиж байгаа орнуудад санхүүгийн тусламж үзүүлэх тухай асуудал АНУ-ын Конгрессоор хэлэлцэгдэж байгааг сонссоноо дурдаж, Монгол Улсыг уг тусламжид хамруулж өгөхийг мөн хүссэн ажээ.

АНУ-ын их дээд сургуулиудад суралцах монгол залуусын тоог нэмэгдүүлэх үүднээс хамтарсан сан байгуулах, энэ хүрээнд Америкийн Фулбрайтын санг өргөжүүлэх саналыг мөн тавьжээ. Хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаанд сэтгэл хангалуун байгаагаа тэмдэглэж, Монголын цэрэг дайчдыг АНУ-д суралцуулах, бэлтгэхэд анхаарахыг хүссэн байна. Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 64 дүгээр чуулганы үеэр болох НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн сонгуульд нэрээ дэвшүүлснийг дурдаж, дэмжлэг хүсчээ.

ТНБД Х.Клинтон хоёр талын харилцааны асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөнд талархлаа илэрхийлж, Конгрессоор хэлэлцэгдэж байгаа эдийн засгийн тусламжид Монгол Улсыг хамруулах асуудлыг нааштайгаар авч үзэхээ мэдэгдэн, Монголоос илүү олон оюутан сургах талаар хамтарсан сан байгуулах саналыг талархан хүлээн авч буйгаа илэрхийлсэн байна. Мөн хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэхэд “Ил тод байдлын” хэлэлцээр байгуулахыг дэмжиж байгаагаа илэрхийлжээ. ТНБД Х.Клинтон МСС-гийн Төмөр замын төслийн хөрөнгийг өөр төсөлд шилжүүлэх асуудлыг анхааралтай судлан үзэхээ илэрхийлж, Монголын эрчим хүчний дотоод хангамжийн байдал ямар байгаа талаар сонирхож байсан байна.

2009 оны 6 дугаар сард Монгол-Америкийн дөрөв дэх Бизнес Форум зохигдож, Гадаад харилцааны сайд нээлтэд оролцож, төлөөлөгчдөд хандаж үг хэлсэн байна. Энэхүү арга хэмжээнд Монгол, Америкийн талаас нийтдээ 90 орчим төлөөлөгч оролцож байгаа аж. Хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ил тод байдлын хэлэлцээр байгуулах нь зүйтэй гэж хоёр тал санал нэгдсэн байна. Ил тод байдлын хэлэлцээр байгуулснаар хоёр орны хөрөнгө оруулагчдад илүү итгэлийг бүрдүүлж, тууштай хөрөнгө оруулж найдвартай бизнес үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл бүрдэнэ гэж хоёр тал санал нэгтэй үзэв. Түүнчлэн, хоёр яам харилцан санаа бодлоо солилцох, туршлага судлахад харилцан форум, воркшоп, семинар зэрэг арга хэмжээг зохион байгуулж байх талаар тохиролцжээ. Америкийн хөрөнгө оруулагчид, компаниуд байгаль орчны стандартыг чанд мөрддөгийг сайд Лок тэмдэглэж, Америкийн томоохон компаниуд Монголд ороход дэмжлэг үзүүлэхийг Монголын талаас хүсчээ.

III

Монгол Улс, АНУ-ын харилцаа хамтын ажиллагаанд худалдаа, эдийн засгийн харилцаа чухал ач холбогдолтой байдаг юм. Монгол Улс, АНУ-ын хооронд эдийн засгийн харилцаа нь хоёр улс 1987 онд дипломат харилцаа тогтоон, 1990-ээд онд Монголд өрнөсөн ардчилал, шинэчлэлийг АНУ анхнаас тууштай дэмжсэн тэр үеэс өргөн хүрээтэй эхэлж, хөгжиж байна. Өнгөрсөн харилцаанд Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг тавих, бэхжүүлэхэд шийдвэрлэх үүргийг

АНУ дангаараа гүйцэтгэж ирсэн билээ. Монгол Улс, АНУ-ын харилцаа иж бүрэн түншлэлийн түвшинд хүрч батжин тогтох явцад худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа далайцтайгаар өргөжиж байна. Өнөөгийн байдлаар АНУ Монгол Улсын экспортын хоёр дахь томоохон түнш боллоо. АНУ-ын хөрөнгө оруулагчид Монголын талд хөрөнгө оруулан, ялангуяа, уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхол өсөн нэмэгдэж байна. Монгол Улс АНУ-ын хөрөнгө оруулалтыг аль болохоор нэмэгдүүлэх, түүнийг эрчимжүүлэх, замаар өөрийн эдийн засгийн аюулгүй байдлаа хангахад анхаарлаа хандуулдаг юм. Иймээс, дэлхийн хүчирхэг эдийн засагтай АНУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэх чиглэлээр Монгол Улс идэвхтэй бодлого, үйл ажиллагаа явуулж байгааг 2007-2009 оны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг харуулж байна.

IV

Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн хөгжлийг АНУ тууштай дэмжиж, томоохон хандивлагч болов. АНУ-аас Монгол Улсад үзүүлэх дэмжлэг болон хэрэгжүүлэх буй хөтөлбөрийг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /ОУХА/ удирдан хэрэгжүүлсээр ирлээ. АНУ-ын ОУХА нь 1991 онд анхны тусламжийн хөтөлбөрөө эхлүүлсэн 10 сая ам.доллартай тэнцэх яаралтай санхүүгийн тусламж үзүүлсэн тэр цагаас хойш буцалтгүй тусламж үзүүлсээр байгаа билээ. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын эрчим хүчний тулгамдсан асуудал, эрүүл мэнд, хүнсний яаралтай тусламж, эдийн засаг, улс төрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан бөгөөд оруулсаар байгаа юм. Монгол Улсад 1991-2008 оны хооронд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг /USAID/-ийн тусламж нийт хэмжээ нь 174.5 сая ам.доллар болсон бөгөөд АНУ-ын засаг захиргаа 2009 онд нэмж 10.4 сая ам.долларын тусламж үзүүлэхээр болсон билээ. Коммунист байгууламжаас ардчилсан сонголттой засгийн газар мөн зах зээлд түшиглэсэн эдийн засагтай улс болох шилжилтийн үйл явцад дэмжлэг үзүүлэх нь Америкийн нэн түрүүний сонирхол болж байгаа юм. 2007 оны санхүүгийн жилд энэ хоёр төсөлд зориулсан Америкийн зардал 7.5 сая долларыг бүрдүүлэв. Монгол Улсын татварын шинэчлэл, хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, аялал жуулчлал, хөдөө тосгоны оршин суугчдад бизнесийн боловсрол олгох талын арга замыг бусад төслүүддээ тусгасаар ирсэн болохыг дурдвал зохино.

АНУ-ын ОУХА нь 2004-2008 онд хамтран ажиллах стратегийг хэрэгжүүлэн ажилласан юм. Энэхүү стратегийн үндсэн зорилго нь Монгол Улсад зах зээлийн тогтвортой эдийн засгийг хөгжүүлэхэд голчлон чиглэгдсэн байлаа. Тэрчлэн АНУ-ын ОУХА нь Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулах сонирхолыг дээшлүүлэхэд туслахыг зорьсон нь үр

дүнгээ өглөө. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт түүний дотор АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхой түвшинд хүртэл нэмэгдүүлэх нь манай эдийн засагт чанарын өсөлт бий болж гадаадын зээл, тусламжаас хараат байх явдал багасахад түлхэц болох билээ. Монгол Улс хөрөнгө оруулалтын болон бизнесийн орчинг сайжруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад анхаарал хандуулж байгаа боловч тодорхой бэрхшээлүүд бас оршсоор байгаа юм. Иймд АНУ, Монгол Улсын хооронд хөрөнгө оруулалт, эдийн засгийн аюулгүй байдал зэрэг салбарт хамтын ажиллагааг улам өргөжүүлэхийн төлөө АНУ-ын ОУХА-тай цаашид ч хамтран ажиллах ч чухал хэвээр байна.

ХАЁТ-ын хөрөнгийн ихэнхийг түлш, эрчим хүчний болон дэд бүтцийн салбарын үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, сэлбэг хэрэгслээр хангах, техник технологийг боловсронгуй болгох, үйлдвэрийн хэвийн ажиллагааг хангахад зориулан ашигласан байна. Энэхүү тусламж хэдийгээр хөгжлийн гэдэг нэртэй боловч хөрөнгө нь шинэ хүчин чадал буй болгож, хөгжлийн өсөлтөд нөлөөлөх, хөрөнгө оруулалтын эх үүсвэр болж чадахгүй эргээд гадаад эдийн засгийн харилцаанд оролцох бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ болон хувирахгүй байна. Монгол Улс зээл тусламжаас хараат байдлаараа дэлхийд тавдугаарт ордог атлаа эдийн засгийн хөгжлийн төвшингөөрөө 150 дугаар байранд байна. Цаашдаа хөгжлийн хөрөнгийг түр зуурын цаг үеийн тулгамдсан арга хэмжээнд зарцуулах, үр ашиг багатай олон янзын төсөл боловсруулах улсын төсвийн алдагдлыг гадаадын хөрөнгийн урсгалаар нөхдөгийг болиулж, эдийн засгийн өсөлтийг хангах хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгох тодорхой чиглэл, зорилготой ашиглах хэрэгтэй юм.

АНУ-аас хөгжлийн тусламж авч байгаагийн эцсийн зорилго бол Монгол Улс нь эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүрч, хүн амын орлого нэмэгдүүлснээр гадаадын зээл, тусламжаас бүрэн татгалзахад оршино. АНУ-ын хөгжлийн тусламжийг цаашид манай орны иргэдийн боловсрол, шинжлэх ухааны салбарт түлхүү чиглүүлбэл, эцэст Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын үйл хэрэгт жинтэй хувь нэмэр болох нь гарцаагүй юм. Дэлхийн хөгжсөн орнуудын туршлагаас харахад худалдаа болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр эдийн засгийн өсөлтийг хурдасган, эдийн засгийн бие даасан хөгжлийг хангаж байжээ.

V

АНУ нь Монгол Улсын гадаад худалдааны гол түнш нь билээ. АНУ-ын худалдаа, бизнесийн салбарынхан Монголд хөрөнгө оруулах, худалдаа хийх чиглэлд идэвхийлэн оролцож, манай эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулж ирсэн бөгөөд цаашид улам өсөх магадлалтай. АНУ нь Монголын зах зээл болж байгааг мөн тэмдэглэн хэлэх хэрэгтэй юм.

Монгол Улс-АНУ-ын худалдааны эргэлт¹
/2005-2008 онуудад/ оны үнээр сая ам.доллар

	2005	2006	2007	2008
Нийт эргэлт	189.6	162.6	155.6	198.3
Экспорт	152.5	119.0	99.9	114.2
Импорт	37.1	43.6	55.7	84.1

Эндээс 2008 оноос худалдааны хэмжээ нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Монгол Улсын АНУ-тай хийсэн худалдааны хэмжээ нь 2008 онд экспортын бүтэцэд 4.5%, импортод 2.6%-ийг эзэлсэн² нь нийт бүтэцэд өчүүхэн байгаа байдал ажиглагдаж байгаа нь бидний зүгээс гол анхаарах асуудал болоод байгаа юм.

Монгол Улс нь Америкийн хувьд харьцангуй жижиг худалдааны түнш юм. 2008 онд Монгол Улс Америкийн экспортын зах зээлд 164 дүгээр (57.2 сая доллар)-т, мөн импорт 139 дүгээр (52.8 сая доллар) байр эзэлж байв. 2000-2008 онд Америкаас Монгол руу экспорт 3 дахин нэмэгдсэн хэдий боловч бага хэмжээтэй байсаар байгаа юм. Монгол Улсаас Америк руу оруулж байгаа импорт 2004 онд 239.1 сая долларт хүрч дээд цэгтээ очсон ч Америкийн хувцасны бүтээгдэхүүний импорт огцом буурснаас болж импорт (Монгол Улсаас Америк руу оруулж байгаа хувцас нь бүтээгдэхүүний импорт 134 сая доллар (2005 онд)-оос 40 сая доллар (2008 онд) болж буурсан буюу (70%-иар буурсан юм) жил бүр хурдацтай буурсан байв.³ 2008 онд Монгол руу гаргаж байгаа Америкийн гол экспортод хөдөлгүүрт ачаа тээврийн хэрэгсэл, хөдөө аж ахуй бас барилга байгууламжийн тоног төхөөрөмж, төмөр замын материалууд эзэлж байжээ. Монголоос Америк руу оруулж ирж байгаа үндсэн гурав нь импортын төрөлд хувцас, химийн төрлийн, амьтаны арьс үс эзэлж байна. Америкийн Монгол руу экспортолж буй экспорт 2009 оны 1-4 сарын хооронд өнгөрсөн 2008 оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд 16.4 % харин импорт 87%-иар буурсан байгааг Америкийн мэдээлэл харуулж байна.

АНУ-ын Монгол Улстай хийж буй эд барааны худалдаа:
2000 он - 2008 он (сая доллараар, % өөрчлөлт)⁴

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2000/2008 % өөрчлөлт
Экспорт	17.7	12.1	66.3	20.7	28.1	21.8	23.0	26.1	57.2	223.2
Импорт	116.6	143.6	161.5	183.4	239.1	143.7	113.9	83.5	52.8	-54.7

**Америкаас Монгол руу гаргаж буй үндсэн экспорт:
2005 он-2008 он⁵**

Хойд америкийн үйлдвэрийн ангиллын систем Тоо, бараа бүтээгдэхүүн	2005	2006	2007	2008	% өөрчлөлт 2007-2008
	1000 долларт				
3361, авто машин	2,153	1,740	2,491	10,067	304.1
3331, хөдөө аж ахуйн, барилгын тоног төхөөрөмж	4,840	4,086	2,291	9,197	301.4
3365, төмөр замын материал	142	23	7	5,423	75,728.4
3342, харилцаа холбооны тоног төхөөрөмж	632	1,068	1,279	4,678	265.8
3345, эмчилгээний, хэмжих, хянах багаж хэрэгсэл	474	1,535	1,276	4,405	245.2

**Монголоос Америк руу оруулж буй үндсэн импорт:
2005-2008 он**

Хойд америкийн үйлдвэрийн ангиллын систем Тоо, бараа бүтээгдэхүүн	2005	2006	2007	2008	% өөрчлөлт 2007-2008
	1000 долларт				
3152, хувцас	134,426	103,725	71,503	39,619	-44.6
3251, гол химийн бүтээгдэхүүн	0	0	0	6,217	NA
1124, хонь, ямаа амьтдын арьс, үс	300	1,965	1,454	1,989	38.8
2123, металын бус ашигт малтмал	5,436	4,745	4,397	1,738	-60.5
2122, хүдэр	76	367	2,544	829	67.4

2004 оны 7 сарын 15-нд худалдааны маргааныг шийдэх мөн хоёр талын худалдаа арилжааны хэлхээ холбоог өргөжүүлж хөгжүүлэхийн тулд АНУ Монгол Улстай хийж буй Худалдаа Хөрөнгө Оруулалтын Бүтцийн гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Худалдаа Хөрөнгө Оруулалт Бүтцийн Гэрээний талаар жил бүр уулзалт хийж ирсэн бөгөөд оюуны өмч, стандартийн хөгжил, ил тод байдлыг хамгаалахтай холбоотой арга замыг чухалчилсан байна. Хоёр тал хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, хоёр талын худалдааг хэрхэн нэмэгдүүлэх тал дээр хувийн хэвшлийн салбарынхан, засгийн газрыг хамааруулан жил бүр хэлэлцэн байхын тулд Америк, Монголын бизнес форум үүсгэн байгуулжээ. Цөмийн энерги, газ, нүүрсний уурхай,

энергийн хөгжилд чиглэсэн бизнес форумыг 2009 оны 6 сард Вашингтон, ДС -д зохион байгуулсан билээ.

Монгол Улс нь мөн АНУ-ын МСС-гаас тусламж дэмжлэг авах эрхтэй болсон билээ. 2006 оны 6 сард Америкийн Монгол Судлалын Төвийн тэмдэглэлд тусгасанаар, гадаадын хөрөнгө оруулалт мөн худалдааг ихээр урамшуулж буй бодлогыг дэмжиж байгаа гадаадын тусламжинд хамааралтай болж буй хараат байдлыг Монгол Улс багасгах талаар Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайд Памилиа Слүц мэдээлжээ. 15 жилийн турш Монгол Улс гадаадаас тусламжинд 2 тэрбум доллар авсан (Дэлхийн банк, олон улсын мөнгөн сангийн мэдээллийн дагуу), энэ нь тусламж жилд 300 сая доллар болж, иймээс Монгол Улс дэлхийд гадаадын тусламжаас маш их хамааралтай улсуудын нэг болсон байна.

Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан Монгол, Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөл 2007, 2008 онд хуралдаж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд учирч буй саад тогторыг арилгах, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлыг хэлэлцжээ. Худалдаа, татвар, оюуны өмч, технологи шилжүүлэх асуудлаар хэлэлцээ явуулах, хэлэлцээр байгуулах асуудал яригдан, бодит нөхцөл бүрдэж байгаа ажээ.

АНУ-тай Чөлөөт Худалдааны Хэлэлцээр /ЧХХ/ байгуулах нь Монгол Улсад эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой билээ. Энэхүү хэлэлцээрийг байгуулсанаар АНУ руу гарах экспортын барааны татварыг үлэмж буруулах, улмаар тэглэх, худалдаанд учирч буй хориг саадыг хөнгөвчлөх, Монгол Улсад АНУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тогтвортой таатай орчин бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Худалдааны чөлөөт хэлэлцээр байгуулахад Монгол Улс өөрийн зүгээс ихээхэн ач холбогдол өгч байна.

Мөн АНУ, Монгол Улсын хооронд ЧХХ байгуулахыг АНУ-ын Сенат болон төлөөлөгчдийн танхимын тодорхой гишүүд дэмжиж тус тус тогтоолын төслийг Конгресст оруулсан билээ. АНУ-тай ЧХХ байгуулах бэлтгэл ажлууд хийгдэж байгааг дурдахын хамт ЧХХ байгуулахаас өмнө монголын талд худалдааны дэглэм, хуулийн тогтолцоо зэрэгт зарим өөрчлөлт хийхийг санал болгож байгаа нь⁶ уг асуудал ойрын хугацаанд анхаарал татсан асуудал хэвээр байх төлөв ажиглагдаж байна. АНУ-ын Монгол Улсад хөрөнгө оруулсан болон оруулах томоохон компаниуд уг хэлэлцээрийг байгуулахыг дэмжихээр байгаа билээ. ЧХХ байгуулах нь Монгол Улсын хөгжлийн хурдац, далайцыг нэмэгдүүлээд зогсохгүй, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл болно.

Гадаад худалдаа нь гадаад эдийн засгийн харилцааны нийтлэг бөгөөд хязгаарлагдмал хэлбэр юм. Бараа үйлчилгээний нэр төрөл, эрэлт,

өрсөлдөх чадвараас гадаад худалдаанд эзлэх байр суурь тодорхойлогдоно, тэнцэл түүнээс хамаарна. Манай экспорт цөөн нэрийн түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнээс бүрддэг хэвээр байна. Өнөөгийн байдлаар АНУ-тай хийж буй Монголын гадаад худалдаа, эдийн засгийн өсөлтийг хангахад жинтэй хувь нэмэр оруулах эх үүсвэр болж чадаагүй байна. Монгол Улсын АНУ-тай хийж буй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, эзэлж буй байр суурь нь дэлхийн зах зээлд орж чадаагүй хэвээр байна. Энэ байдал удаан үргэлжилбэл дэлхийн хөгжлөөс хочорч, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхийг үгүйсгэх аргагүй юм.

VI

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулах, бизнес эрхлэх эрх зүй таатай орчин бүрдсэн тэр үеэс АНУ-аас Монголд хөрөнгө оруулах болсон билээ. Монгол Улсад АНУ-ын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөхөд хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчин бүрдүүлэх талаархи хүчин чармайлт нөлөөлөв.

АНУ-ын Засгийн газар Монгол дахь АНУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замыг идэвхтэй хайж байна. Ер нь Монгол, Америкийн эдийн засгийн харилцаанд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэн чухал үүрэгтэй нь улам тодорхой болж байгаа билээ. Гэхдээ, Америкийн компаниуд Монгол дахь бизнес, хөрөнгө оруулалтын орчинг хүндрэлтэй гэж үзсээр байгаа юм. Хөрөнгө оруулагчдын санаа зовж буй асуудлын тоонд ил тод байдлыг нэмэгдүүлэх, оюуны өмчийг хамгаалах, гол гол салбаруудын хувьчлалыг үргэлжүүлэх, зах зээлд төр засгийн оролцоог багасгах зэрэг асуудал орж байна.

Гадаад Хэргийн Яамны 2006 оны үйл ажиллагааны тайланд дурдахдаа, “АНУ-аас манай улсад оруулж буй шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдээгүй /гадаадын нийт хөрөнгө оруулалтын 4 орчим хувийг эзэлж байна/ боловч америкийн бизнесийн салбарынхан манайхыг сонирхох хандлагатай хэмээн дурдсан байна.

Энд Вагнер Ази тоног төхөрөмж, ГЛ монполимет Соко Тамсаг, Монгол ИНК зэрэг геологи, уул уурхайн газрын тосны эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт, Эрдмийн компани катодын зэс үйлдвэрлэх, Монгол Амикаль, Форте Кашмер зэрэг компани ноолуур боловсруулах, Кока-Кола хүнсний салбарт, цахим холбоо, интернетийн үйлчилгээ үзүүлдэг Стифон, оёдлын үйлдвэрлэл салбарын Тинфар интернэйшнл зэргийг дурдаж болох ажээ.

2007 оны эхээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байсан АНУ-ын хөрөнгө оруулалттай 110 орчим аж ахуйн нэгжийн 25 нь худалдаа, үйлчилгээний, 17 нь геологийн хайгуул, олборлолтын, 12 нь аялал жуулчлалын, 10 нь хөнгөн үйлдвэрийн, 5 нь банк санхүүгийн,

5 нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулах чиглэлээр ажиллаж, үлдсэн бусад салбарт ажиллаж байна.

1990-2007 оны хооронд АНУ-ын нийт 110 компани 88 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Эдгээрийн 53 нь Америкийн зуун хувийн хөрөнгө оруулалттай юм. АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ жил жилд харилцан адилгүй байв. 1996 онд 10,25 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн 7 сая ам.доллар бол 2003 онд 115 сая ам.доллар, 2004 онд 128,519 ам доллар 2006 онд 37 сая ам доллар хөрөнгө оруулалт хийгджээ. АНУ-ын хөрөнгө оруулалтын хэмжээ бусад хөрөнгө оруулсан улсынхтай харьцуулахад харьцангуй бага, 2007 оны эхээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын 4 орчим хувийг л эзэлж байна. Америкийн бизнесийн салбарынхан, тухайлбал уул уурхайн компаниуд Монголыг сонирхож байна. Тухайлбал, дэлхийн хамгийн том нүүрсний компани болох АНУ-ын Пи боди Энержи нь Монголд хөрөнгө оруулах, бизнес эрхлэх боломжийг судалж, төлөөлөгчийн газрын нээжээ.

2007 оны нэгдүгээр сарын 16-нд Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд Америкийн “Мерилл линч” /Merrill lynch/ санхүүгийн корпорацийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан билээ. Төлөөлөгчдийн тэргүүн “Мерилл линч”-ийн Ази, Номхон далай дахь Ерөнхий үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын банкны хамтрагч захирал Хэнри Айлифф Монголын эдийн засгийн нөхцөл байдал таатай байгаа нь гаднын хөрөнгө оруулагчдыг татах сайхан боломжийг олгож байна гэж үзжээ. Тэрээр Монголд ямар салбарт хөрөнгө оруулах боломжийг судалж байгаагаа дурдаж, хамтын ажиллагааныхаа хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 5 одтой дөрвөн зочид буудал бүхий аялал жуулчлалын томоохон цогцолбор барих ажлыг санхүүжүүлэхээр болжээ. Уг цогцолборын төсөлд 1 тэрбум доллар зарцуулах юм байна.

2008 оны эцсээр Монгол Улсад орж ирсэн Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2.5 тэрбум ам.доллар хүрэв. Монголд шууд хөрөнгө оруулсан томоохон гадаадын хөрөнгө оруулагчид нь 2004 оны эцсийн байдлаар нийт дүнгээр БНХАУ /47.7%/, Канад /12.2%/, Өмнөд Солонгос /7.3%/ байсан бол АНУ нь 2.5%-ийг эзэлж, гадаадын шууд хөрөнгө оруулагчдын дунд зургаадугаар байранд орж байв. 2008 оны байдлаар Монгол Улсад АНУ-ын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай 216 компани нийт 99.1 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийгээд байв. Монгол Улсад 2008 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 682.5 сая ам.доллар болж, 2009 онд IMF-ийн төлөвлөж байсанаас 316.5 сая ам.доллараар буурсан нь дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалсан байв.

2009 оны 8-р сарын 28-ны өдөр АНУ-ын Худалдаа, хөгжлийн агентлагаас Ялгуун Интернейшнл ХХК-д цементийн үйлдвэрлэлийг

дэмжих зорилгоор Монгол Улсын төмөр замын гол чиглэлийн дагуу хуурай аргаар цемент үйлдвэрлэх цементийн үйлдвэрийг байгуулахад шаардагдах хөрөнгө мөнгийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр хүлээлгэн өгсөн юм. 250 мянган ам.долларын буцалтгүй тусламжийг хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагаа Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-нд болж, холбогдох бичиг баримтыг АНУ-ын Засгийн газрын өмнөөс АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Марк Минтон болон Ялгуун Интернейшнл ХХК-ний Ерөнхий захирал Нацагдорж Зоноров нар гарын үсэг зуржээ. Элчин сайд Марк Минтон хэлэхдээ, “Чухам яг ийм, үйлдвэрлэлд хэрэгцээтэй дэд бүтцийг хөгжүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлдэг нь манай хоёр улсын хамтын ажиллагааны нэгэн чухал шинж чанар юм” гээд “Сүүлийн хэдэн жилд Монголд эдийн засгийн эрчтэй хөгжлийг дагаад цементийн эрэл хэрэгцээ ихээр өссөн билээ. Харамсалтай нь үүний 90 хувийг гаднаас оруулж ирдэг. Өндөр эрэл хэрэгцээ, тээвэрлэлтийн өртөг гэх хоёр хүчин зүйл нь эцсийн дүндээ цементийн үнийг хөөргөж өгсөн. Энэ нь эргээд тус улсын барилгын салбарын хөгжлийг гацаанд оруулж байна” гэжээ. Шинээр баригдах үйлдвэр нь жилд нэг сая метр тонн буюу Монголын цементийн бараг бүтэн жилийн хэрэгцээг хангахуйц хүчин чадалтай байхаар төлөвлөгдсөн байгаа ажээ. АНУ-ын ХХА-ын Захирлын үүрэг гүйцэтгэгч Леокадиа Зак хэлэхдээ “Цементийн шинэ үйлдвэр барих энэхүү төсөл нь дотоодын цементийн үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, эрэл хэрэгцээг өөрсдийн хүчээр чөлөөтэй хангадаг болоход тус нэмэр болохоос гадна Монгол дахь барилгын материалын үнэ өртөгт асар их өөрчлөлт авчрах болно” гэв. Ингэснээр Монгол Улсад АНУ-гаас технологи, үйлчилгээ оруулж ирж дэд бүтцийг хөгжүүлэх үнэ өртөгийг бууруулах болно. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийн судалгаа, үнэлгээ тооцоог гаргахын тулд Ялгуун компани нь Пеннсилвани мужийн Бетлехем хотод төв нь байдаг цемент боловсруулах тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэгч FLSmidth /ФЛСмидт/ компанийг хамтран ажиллах түншээрээ сонгосон байна. FLSmidth компани нь төсөл хэрэгжүүлэх судалгаа, үнэлгээг хийж гаргах ажилд зориулж нэмж хөрөнгө мөнгөний туслалцаа үзүүлэхээр болсон юм.

АНУ-ын хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг татах олон төрлийн шийдвэр гаргаж, арга хэмжээ авч байгаа боловч, хөрөнгө оруулалт хийж буй талынхаа сэтгэлд хүрэхгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг харагдахгүй байгааг хэлэх хэрэгтэй юм. Энэ нь ялангуяа, уул уурхайн салбарт дахь хөрөнгө оруулалтын орчин зарим талаар ойлгомжгүй байгаатай холбоотой болов уу. Мөн Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинг гадаадад сурталчлах, явдал хангалтгүй, дотоод байдал тогтворгүй, хууль дүрмийг ойр ойр өөрчлөх, татварын тогтолцоо, хүнд суртал, авилга гэх мэт таагүй зүйл хөрөнгө оруулагчдыг үргээж байгаа зэргийг арилгах нь чухал билээ.

АНУ нь гадаадад хөрөнгө оруулалт хийх талаар баялаг туршлагатай юм. Дэлхийн олон орны эрчимтэй хөгжил нь АНУ-ын хөрөнгө оруулалт тусламжтай шууд холбоотой билээ. Тиймээс улс орныхоо эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлыг хангах асуудлыг АНУ-ын хөрөнгө оруулалт, тусламжгүйгээр төсөөлөх аргагүй юм. АНУ-ын хөрөнгө оруулалтыг даган дэлхийд шинжлэх ухаанаар тэргүүлэх буй АНУ-ын шинэ өндөр технологи, өндөр мэдлэг орж ирнэ. Энэ нь ирээдүйд Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг бататган хангах баттай үндсийг бүрдүүлнэ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт бол хөрөнгө, технологи, мэдлэг зах зээл, хамтдаа орж ирдэг эдийн засгийн харилцааны хамгийн дэвшилттэй хэлбэрийн нэг юм. 1990-2008 онд оруулсан гадаадын хөрөнгө нь зөв ашиглаж чадвал үйлдвэрлэл үйлчилгээний хүрээг өргөжүүлж, ажлын байр, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулж, хөгжлийг түргэтгэхэд бодитой хувь нэмэр оруулах боломжтой хэлбэр гэдэг нь харагдлаа. Нөхцөл нь өрсөлдөх чадвар бүхий эрх зүй, татварын тогтвортой байдал хангагдсан байх ёстой юм байна. Улс төр, нийгмийн тогтвортой байдал эрсдлээс хамгаалах таатай нөхцөл зэргийг харгалзан харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан хамтын ажиллагааны хэлбэр юм. Эдгээр нөхцлийг бүрдүүлэхгүй бол гадаадын хөрөнгө орж ирэх боломж хязгаарлагдах болно.

VII

АНУ нь МСС-гийн хөтөлбөрийн хүрээнд 120 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг төмөр замын салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байв. Энэ нь зүтгүүр, вагон, мэдээлэл, дохиоллын хэрэгслийг АНУ-ын буцалтгүй тусламжаар авахаар төлөвлөж байгаа юм. АНУ, Монгол Улсын Засгийн газрын хооронд гэрээ батлагдвал 2007 оны төгсгөл 2008 оны эхэнд МСС-ийн хөтөлбөр эхэлж, төмөр замын тоног төхөөрөмж Монголд орж ирэхээр байлаа. Үүнийг Монголын төмөр зам, төмөр замаар үйлчлүүлэх сонирхолтой томоохон ачаа илгээгчид, том уурхай, цахилгаан станц ихээр сонирхож байсан юм. Мөн Ази, Европыг холбосон цаг хугацааны хувьд хамгийн богино, орон зайн хувьд хамгийн дөт зам билээ. Энд оруулсан хөрөнгө харьцангуй бага хугацаанд үр ашгаа өгөх нь тодорхой байлаа.

2009 онд АНУ-ын МСС-аас Монгол Улсад томоохон төсөл хэрэгжүүлэхэд зориулан 284.9 сая долларын буцалтгүй тусламжийг таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажил эхлэв. Уг төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төслүүдийн төмөр замын салбарт хэрэгжихээс бусад нь төлөвлөсөн хугацаандаа хэвийн явагдаж эхэлсэн билээ. Харин Төмөр замын төслийг хэрэгжүүлэх хүрээнд “Мянганы Сорилтын Гэрээ” болон манай бусад хууль тогтоомжийн дагуу Монгол-Оросын хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж болох Улаанбаатар төмөр замд төсөл

хэрэгжүүлэх боломжгүй болсон билээ. Цаашид хэрхэх талаар манай тал Америкийн талтай удаа дараа зөвлөлдөж, санал солилцсоны үндсэн дээр уг төслийн оронд өөр төсөл хэрэгжүүлэх, эсвэл хэрэгжүүлж буй гурван төслийг өргөжүүлэх зэрэг боломжийг эрэлхийлж эхэлсэн билээ. Америкийн тал ч төмөр замын төслийн оронд өөр төсөл хэрэгжүүлэх боломж, хувилбарыг эрэлхийлэх гэсэн манай байр суурийг хүлээн зөвшөөрч байгаа гэдгээ хариу мэдэгдсэн юм. Монголын Засгийн газраас халдварт өвчнийг бууруулах эрүүл мэндийн төслөөс гадна “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам” төслийг өргөжүүлэх санал дэвшүүлсэн билээ. Мөн Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын төслийг өргөжүүлэх төсөлд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, удаан болон богино хугацааны сургалтыг хослуулсан, АНУ-ын олон нийтийн коллежийн загвар дээр түшиглэсэн загвар сургуулиудыг бий болгохоор төлөвлөжээ. МСС-д Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээг бууруулах цогц арга хэмжээний төслийг санал болгохоор гүйцэтгэх засаглалынхан бэлтгэсэн байлаа.

VIII

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, үндэсний эрх ашигт нийцүүлэх нэн тэргүүний зорилтыг хэрэгжүүлэхэд АНУ-тай худалдаа, эдийн засгийн харилцан байдлыг гүнзгий судлан дүгнэж байх нь чухал. 2007 оны 1 дүгээр сарын 26-нд Гадаад хэргийн яаманд болсон “Монгол, АНУ-ын харилцаа 21 дүгээр зуунд: иж бүрэн түншлэлийн харилцаа” эрдэм шинжилгээний бага хурал энэ талаарх амжилттай ажил болсон билээ. Энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан цуврал арга хэмжээнүүдийн нэг байсан бөгөөд бага хуралд УИХ-ын гишүүд, төрийн яам, газруудын холбогдох ажилтнууд, эрдэмтэд, судлаачид, ахмад дипломатчид, монгол-америкийн харилцааны түүх, байдал, төлвийг сонирхдог, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхийн төлөө сэтгэл гарган зүтгэдэг хүмүүс оролцжээ. Эрдэм шинжилгээний бага хурлаар цаг үеэ олсон асуудлаар хэд хэдэн сонирхолтой илтгэлүүд тавжээ. Үүнд: ГХЯ-ны Америк, Ойрхи Дорнод, Африкийн газрын захирал Ц.Жамбалдорж “Монгол Улс, АНУ-ын харилцаа XXI зуунд: иж бүрэн түншлэлийн харилцаа”, АНУ-ын Элчин сайд М.Минтон “Анд нөхөд ба хөршүүд: АНУ, Монголын харилцааны өнгөрсөн, одоо, ирээдүй үе”, УХЯ-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга В.Энхболд “Монгол Улс-АНУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал ба хэтийн төлөв”, Стратегийн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Д.Мөнх-Очир “АНУ-ын 2008 он хүртэлх улс төрийн прогноз, Монгол Улс-АНУ-ын харилцааны хэтийн төлөв”, Олон Улс Судлалын Хүрээлэнгийн

эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Ц.Баатар “АНУ-ын хөгжлийн тусламж Монголд”, БХЯ-ны “Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа” сэдвээр тус тус илтгэл тавьж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлжээ. Монгол-Америкийн иж бүрэн түншлэлийн харилцааны үзэл баримталыг тодруулах, гүнзгийрүүлэн ойлгоход энэ бага хурал тус дөхөм үзүүлж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, ялангуяа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын чиглэл, зорилтыг тодорхойлоход хувь нэмэр оруулсан чухал арга хэмжээ болсон билээ.⁷

2009 оны 6 дугаар сард АНУ-д айлчилсан Гадаад харилцааны сайд С.Батболд Америкийн Сенатын гишүүн ноён Ричард Лугартай уулзаж Монголыг дэмжиж ирсэнд нь талархал илэрхийлж, Америкт суралцдаг, суралцах сонирхолтой Монголын оюутнуудын тэтгэлэгийг нэмэгдүүлэх асуудлаар тусалж, дэмжлэг үзүүлэхийг хүссэний дагуу АНУ-д суралцах оюутаны тоо нэмэгдүүлэх зорилгоор Сенатч Ж.Керригийн хамт Монголыг дэмжсэн тогтоолын төсөл боловсруулж Сенатад өргөн барьж буйгаа албан ёсоор мэдэгдсэн сайн боломжийн эхлэл болж байна. 2008 оны байдлаар АНУ-ын ЭСЯ-наас зарладаг Фулбрайтын тэтгэлгийн шугамаар 28 оюутан магистрын сургалтад, Хамфригийн тэтгэлгээр 11 оюутан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байв. Голдуу хувийн болон шашны байгууллагуудын шугамаар 1000 гаруй монгол оюутан (бүрэн бус мэдээгээр) АНУ-д сурч байгаа гэсэн мэдээ гарч байлаа. АНУ-д ЭСЯ-ны 2007 оны 12 дугаар сард хийсэн судалгаагаар 20 мянга орчим монгол иргэд сурч, ажиллаж байв. Тэд голдуу Оакланд, Денвер, Чикаго, Лос Анжелес, Сан Франциско, Сиэтл, Сакраменто, Лас Вегас, Вашингтон, Охайо, Нью-Жерси, Орноак, Юта, Нью-Йорк, Флорида зэрэг хэд хэдэн мужийн 120 орчим хотод оршин сууж байв.

АНУ, Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагаанд иргэдийн харилцаа чухал байрыг эзэлдэг болов. АНУ-ын иргэд Монгол Улсад 90 хоногт визгүй зорчихоор харилцан тохирсон байна. Энэ үеэс хойш АНУ-аас ирэх хүмүүсийн тоо нилээд нэмэгдсэнийг дараах хүснэгтээс харж болно.

Монгол Улсад АНУ-аас ирсэн жуулчид болон зорчигдын тоо⁸

Он	Жуулчид	Зорчигч/орсон	Зорчигч/гарсан
2005	10153	10234	10587
2006	11377	11570	11276
2007	12223	12342	12322
2008	12474	12663	12521

АНУ, Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагаанд батлан хамгаалах салбарын харилцаа чухал байрыг эзэлдэг билээ. Монгол оронд хоёр дахь удаагаа зохион байгуулагдсан “Хааны эрэлд-2007” олон улсын энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлага 2007 оны 8 дүгээр сард 15 өдрийн турш явагдав. Уг арга хэмжээнд Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлагч, адмирал Т.Китинг оролцон хаалтын арга хэмжээнд хэлсэн үгэндээ, даян дэлхийн аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд улс орнууд хамтран ажиллах, Энхийг сахиулах үүрэг чухлаар тавигдаж байна гэж хэлжээ.

“Хааны эрэлд-2008” олон улсын энхийг дэмжих хээрийн хамтарсан сургалт, дадлагын ажиллагаа 2008 оны наймдугаар сард Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд болжээ. Нээлтийн ажиллагаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Н.Энхбаяр хэлсэн үгэндээ Монгол Улс өөрийн цэргийн албан хаагчид, багийг НҮБ-ын болон олон улсын цэргийн ажиллагаанд оролцуулсан мөчөөс эхлэн үндэсний энхийг сахиулагчдаа сургах, дадлагажуулах асуудалд онцгой анхаарал тавьж ирсэн гэжээ. Гадаад, дотоодод болж буй олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургалт дадлагуудад цэргийн багаа оролцуулаад зогсохгүй өөрийн оронд бүс нутгийн орнуудын энхийг сахиулагчдыг цуглуулан туршлагаа хуваалцах, харилцан суралцах боломжийг бий болгохын төлөө ихээхэн зүтгэл гаргасан хэмээн тэмдэглээд, тус улсад жил бүр явагддаг “Хааны эрэлд” энхийг сахиулахын олон улсын хээрийн сургалт дадлагыг тогтмолжуулан хамтран ажиллагч нараа оролцуулах өргөн боломжийг бий болгож байгааг онцлов.

“Хааны эрэлд-2009” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлага дөрөв дэх удаагаа 2009 оны зун манай улсад зохион байгуулагдав. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Номхон далайн цэргийн командлалаас Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэн, энхийг сахиулагчдыг сургаж, дадлагажуулах замаар тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн сургалт, дадлагууд зохион байгуулдаг явдал билээ. Эдгээрийн дотор жил бүрийн гол арга хэмжээ нь бүсийн орнуудыг хамарсан энхийг сахиулахын олон улсын хээрийн сургалт, дадлага байдаг. “Хааны эрэлд-2009” хамтарсан сургалт, дадлагад Монгол Улсаас 444 цэргийн албан хаагч, АНУ, БНСУ, Япон, Энэтхэг, Бангладеш улсын 438 цэргийн албан хаагч, сургагч офицер, ажиглагчид оролцсон юм.

Өнгөрсөн гурван жилд уг хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр энэ арга хэмжээг Монгол Улсад “Хааны эрэлд” гэсэн нэртэйгээр олон улсын салаадын хамтарсан хээрийн сургалт дадлагын хэлбэрээр зохион байгуулсан нь бүс нутгийн орнуудын анхаарлыг татсан үйл явдал болж,

уг сургалт дадлага нь Ази, Номхон далайн орнуудын энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр хэрэгждэг таван том гол арга хэмжээний нэг болж чадсан юм. Энэхүү дөрөв дэх жилдээ зохион байгуулагдаж байгаа энэ сургалт, дадлага нь олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааг нэмэгдүүлэх, мөн энхийг сахиулах ажиллагааны бүс нутгийн сургалтын төв байгуулах нөхцлийг бүрдүүлэх зорилготой аж.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. 2008 он. УБ, 2009. т.270-271
2. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. 2008 он. УБ, 2009. т.283
3. Kerry Dumbaugh and Wayne M.Morrison .Mongolia and U.S.Policy: Political and Economic Relations.www.crs.gov.R134 p.9-11
4. Мөн тэнд р.9-11
5. Мөн тэнд р.9-11
6. Kerry Dumbaugh and Wayne M.Morrison .Mongolia and U.S.Policy: Political and Economic Relations.www.crs.gov.R134 p.11
7. Монгол Улс, АНУ-ын харилцаа XXI зуунд: иж бүрэн түншлэлийн харилцаа”. “Гадаад харилцаа” мэдээллийн товхимол. №05 /181/. 2007 оны 2 дугаар сар.
8. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. 2008 он. УБ, 2009. т.217,298